Монголын ОҮИТБС-ын Ажлын хэсгийн 2019 оны 11-р сарын 29-ний 49-р хуралдаанаар хэлэлцэн, 12- р сарын 10-ний эцэслэн хянаж Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын Үндэсний зөвлөл 2019 оны 12-р сарын 19-ний өдрийн 18- р хуралдаанаараа хэлэлцэн батласан.

**"2020 ОНЫ УРИА- ОҮИТБС-ЫН ШИНЭ СТАНДАРТЫГ СУРТАЛЧЛАХ, ДЭД ЗӨВЛӨЛҮҮДИЙГ ЧАДАВХЖУУЛАХ ЖИЛ" ГҮЙЦЭТГЭЛ/**

**Нэгдүгээр зорилго: ОҮИТБС-ын стандартын шинэ шаардлагуудыг нэвтрүүлэх, төрийн байгууллага, компанийн олон нийтэд зориулсан сүлжээгээр ил тод болгох ажлыг хэвшүүлэх;**
**Үндэслэл:** ОҮИТБС-ын Олон улсын Удирдах хорооноос гишүүн бүх орнуудад шинэ стандартад шилжих зөвлөмжийг хүргүүлээд байна. Ач холбогдол нь төрийн байгууллагууд, тэргүүлэх компаниуд стандартын дагуу ил тод байдлыг үйл ажиллагаандаа хангах, хэвшүүлэх, шинэ шаардлагуудыг хэрэгжүүлэх, нэвтрүүлэх, үйл ажиллагаагаа ойлгомжтой болгох, улмаар хариуцлагатай байдлыг сайжруулахад оршино.
**Зохицуулах байгууллага: Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам**

| ЗОРИЛТУУД | ТӨЛӨВЛӨСӨН АЖИЛ | ҮР ДҮН | ХАРИУЦАХ БАЙГУУЛЛАГА | ХУГАЦАА | ТӨСӨВ | | Гүйцэтгэл 2020 12- р сарын 21-ний байдлаар |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Мөнгөн дүн (мян.төг) | Эх үүсвэр | |
| **Зорилт 1.** ОҮИТБС-ын 2019 оны стандартын шаардлагуудыг хангах арга хэмжээ авах; | 1.1 Стандартын шинэ шаардлагуудын дагуу тайлангийн маягтыг шинэчилэн батлуулах, системд оруулах; | Шинэ шаардлагад нийцсэн тайлангийн маягттай болно. | Үндэсний статистикийн хороо | 1-2-р сар | Шаард-лагагүй | | Үндэсний статисткийн хороо шинэ маягтуудыг 2020 оны 2-р сарын 21 нд зөвшөөрсөний дагуу Ууу уурхай, хүнд үйлдвэрийн 3- р сарын 5-ны А/37 дугаар тушаалаар батлаж, Хууль зүй, дотоодын хэргийн яаман дээр 4-р сарын 21-нд бүртгэгдэж, www.legalinfo.mn дээр хэвлэгдэн, мөрдөгдөж эхлэсэн байна. Эдгээр шинэ маягтыг 8-р сарын 17-ноор эцсийн байдлаар цахим сүлжээнд оруулж, тайлагнуулж эхлэснээс 633 компани тайлангаа илгээсэн байна. |
| | 1.2 Шинэчлэгдсэн маягтуудын дагуу компаниудад аргазүйн сургалт зохион байгуулах; | Компаниудын удирдлага, мэргэжилтнүүд мэдлэгтэй болно. | УУХҮЯ, Ажлын алба | 6-р сар | | | Шинэ маягтыг 5-р сарын 29-нд ОҮИТБС-ын цахим тайлагналын системд анх оруулж, 6-р сард 4 удаагийн цахим сургалт зохион байгуулсан. Үүнд тайлан гаргасан хуучин маягтаар тайлан гарсан 50 гаруй компанийн төлөөлөл оролцсон байна. |
| | 1.3 Шинэчлэгдсэн маягтуудын дагуу ОҮИТБС-ын цахим тайлагналын системээр тайлан гаргуулах; | Тайлангууд гарсан байна. | Тайлан гаргах үүрэг бүхий байгууллагууд, компаниуд | 6-7-р сар | Шаард-лагагүй | | Тайлангийн хуучин маягтаар 1472 компани тайлангаа гаргасан нь гаргах ёстой 2101 компанийн 70 хувь болсон байна. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Зорилт 2.** Хэвшүүлэн ил тод болгох шаардлагатай мэдээллийн сангуудыг бий болгох, сайжруулах; | 2.1 Кадастрын системд ОҮИТБС-ын стандартаар шаардсан өргөдлийн огноо, Бүтээгдэхүүн хуваах гэрээний талбайн солбилцол, сонгон шалгаруулалтын үр дүн, цуцалсан тухай мэдээллийг оруулах, ил тод болгох; | Тусгай зөвшөөрлийн бүртгэл, олголт, БХГ-тэй холбоотой мэдээлэл ил тод болсон байна. | АМГТГ | 1-4-р сар | Шаард-лагагүй | | УУХҮЯ-наас АМГТГ-т дурдсан асуудлуудаар үүрэг өгсөн болно. |
| | 2.2 Төрийн өмчийн компаниудын цахим тайлагналын системд стандартын дагуу нэмэлт оруулах, тайлан гаргуулах, хэвшүүлэх, нийтэд мэдээлэх; | Стандартаар шаардсан төрийн өмчит аж ахуйн нэгжүүдтэй мэдээлэл ил тод болно. | УУХҮЯ, ТӨБЗГ | 1-4-р сар | | | Төрийн болон орон нутгийн өмчит 16 компани хуучин маягтаар тайлан гаргасан байна.[1]<br>Эдгээрээс Монголросцветмет УҮГ шинэ маягтаар тайлан гаргажээ. |
| | 2.3 Дээрх 2.3-д заасан ажлыг хэрэгжүүлэхэд шаардлагатай чадавх нэмэгдүүлэх, арга зүйн сургалт зохион байгуулах; | Стандартаар шаардсан төрийн өмчит аж ахуйн нэгжүүд мэдлэгтэй болно. | УУХҮЯ, ТӨБЗГ, Ажлын алба | 1-2-р сар | 1,000 | АХБ | ТӨК-үүдийн зарим төлөөлөл дээр дурдсан 4 сургалт оролцсон байна. |
| **Зорилт 3.** Гэрээний ил тод байдлыг 2021 оны 1-р сарын 1-нээр хангах;<br><br>; | 3.1 Гэрээний ил тод байдлыг хангах тухай албан ёсны мэдэгдэл танилцуулгыг цахим хуудас дээрээ байршуулах; | Стандартын шаардлагыг хангана. | УУХҮЯ, СЯ, Аймгийн ЗДТГ-ууд | 1-11-р сар | Шаард-лагагүй | | www.iltodgeree.mn хэмээх Гэрээний ил тод байдлын холбоосыг УУХҮЯ-ны цахим хуудас дээр байршуулж, олон нийт хандах боломжтой болсон байна. |
| | 3.2 Энэхүү зорилт үйл ажиллагааны явцын байдалд хагас жилд нэг удаа мониторинг үнэлгээ хийх, хэрэгжилтийг сайжруулах | Үйл ажиллагааны хэрэгжилтийн чанар сайжирсан байна. | ОТОАХ | 7-8-р сар | 1,000 | АХБ | Хэрэгжээгүй. |
| **Зорилт 4.** Хэвшүүлэн ил тод болгох талаар төрийн байгууллагын ажилтнуудын мэдлэг | 4.1 ТЕГ, ГЕГ, НДЕГ,ХХҮГ, ТӨБЗГ- ын ажилтнуудад зориулсан сургалт зохион байгуулах; | Холбогдох байгууллагууда ас гаргах тайлангийн | УУХҮЯ, Ажлын алба | 2-6-р сар | 2,000 | АХБ | 7-р сарын 30-нд СЯ, УУХҮЯ, ТЕГ, ГЕГ, НДЕГ гэсэн 5 байгууллагын төлөөлөлд цахим сургалтыг зохион байгуулсан байна. |

[1] 1/Баянхишиг Хараа, 2/Баянтээг, 3/Гурвансайхан, 4/Могойн гол, 5/Монголросцветмет, 6/Багануур, 7/Мончех ураниум, 8/Оюу Толгой, 9/Сэлэнгийн байгалийн нөөц, 10/Тавантолгой, 11/Шивээ-Овоо, 12/Эрдэнэс Монгол, 13/Эрдэнэс Монгол Ресорс, 14/Кроссфор ворлд майнинг лимитед, 15/Дарханы төмөрлөгийн үйлдвэр, 16/Эрдэнэт Үйлдвэр-

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| ойлголт, чадавхийг нэмэгдүүлэх; | | чанар сайжирна. | | | | | |
| | 4.2 Сангийн яам, УУХҮЯ, АМГТГ-ын ажилтнуудад зориулсан сургалт зохион байгуулах; | Холбогдох байгууллагууда ас гаргах тайлангийн чанар сайжирна. | Сангийн яам, УУХҮЯ, Ажлын алба | 3-6-р сар | 1,000 | АХБ | 7-р сарын 30-нд СЯ, УУХҮЯ, ТЕГ, ГЕГ, НДЕГ гэсэн 5 байгууллагын төлөөлөлд цахим сургалтыг зохион байгуулсан байна. |
| | 4.3 Орон нутгийн засаг захиргааны байгууллагын ажилтнуудад зориулсан сургалт зохион байгуулах; | Холбогдох байгууллагууда ас гаргах тайлангийн чанар сайжирна. | УУХҮЯ, Ажлын алба | 6-10-р сар | 20,000 | АХБ | 4-р сарын 30, 5-р сарын 4-нд 17 аймгийн Дэд зөвлөлийн нарийн бичгийн дарга, 3 аймгийн Дэд зөвлөлийн дарга нар цахим сургалтанд оролцсон. |
| **Нэгээс Дөрөвдүгээр зорилтын дүн** | | | | | **30,000** | **АХБ 30,000** | |

**Хоёрдугаар зорилго: Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төслийг дахин боловсруулж, УИХ-аар батлуулах;**
**Үндэслэл:** Монгол Улсыг 2018 оны 2 дугаар сард дэлхий дахинаа ОҮИТБС-ын стандартыг бүрэн хангасан хоёрдогч орноор зарласан билээ. Гэсэн хэдий ч 2020 оны 1 дүгээр сарын 1-нээс эрдэс баялгийн салбарт үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгжүүдийн ашиг хүртэгч жинхэнэ эздийг ил тод болгох, гэрээний ил тод байдлыг бүрэн хангах, авилгалын эрсдэлийг бууруулах, төрийн байгууллагуудын системээр санхүүгийн бус мэдээллийг тогтмол ил тод болгох зэрэг томоохон зорилтуудыг хангах шаардлага байсаар байна. Монгол Улсад 2007-2018 оныг дуустал 12 жилийн хугацаанд ОҮИТБС-ыг амжилттай хэрэгжүүлэхэд хандивлагч орнууд Дэлхийн банкаар дамжуулан үйл ажиллагааг санхүүжүүлэн буцалтгүй тусламжийг үзүүлж ирсэн ч цаашид тэдний зүгээс ОҮИТБС-ыг Монгол Улсын Засгийн газар манлайлан авч явж, өөриймшүүлэх нь зүйтэй гэж үзэн 2019 оноос эхлэн санхүүжилтээ зогсоосон билээ. 2021 он хүртэл Азийн Хөгжлийн банкнаас техник туслалцааны төслийн хүрээнд ОҮИТБС-ын хэрэгжилтийг дэмжих болно. Иймд цаашид урт хугацаанд ОҮИТБС-ыг хэрэгжүүлэхэд санхүүгийн болон институтын тогтвортой байдлыг хангах, үр нөлөөг улам нэмэгдүүлэх үүднээс бие даасан хуулийн төсөл дахин боловсруулж, батлуулах зорилтыг тавиад байна. .
**Зохицуулах байгууллага**: **Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам**

| ЗОРИЛТУУД | ТӨЛӨВЛӨСӨН АЖИЛ | ҮР ДҮН | ХАРИУЦАХ ТАЛ | ХУГАЦАА | ТӨСӨВ | | Гүйцэтгэл 2020 оны 12-р сарын 21- ний байдлаар |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Мөнгөн дүн (мян.төг) | Эх үүсвэр | |
| **Зорилт 5**: Эрдэс баялгийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төсөл боловсруулах, УИХ-д өргөн барих; | 5.1 Хуулийн ажлын хэсгийг үргэлжлүүлэн ажиллуулах; | Хуулийн төслийг боловсруулах, батлуулах үйл явцыг хангана. | УУХҮЯ | 2019 оны 11- 2020 оны 6-р сар | 1,000 | АХБ | Уур уурхай, хүнд үйлдвэрийн сайдын тушаалаар батлагдсан Ажлын хэсэг ажиллаж байна. |
| | 5.2 Шаардлагатай судалгаануудыг хийж, үзэл баримтлалаа боловсруулж, батлуулах; | Хуулийн үзэл баримтлал батлагдсан байна. | УУХҮЯ, Хуулийн ажлын хэсэг | 2019 оны 11- 2020 оны 6-р сар | 20,000 | ННФ | Хуулийн үзэл баримтлалыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Сангийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайд нар хамтран 2020 оны 8-р сарын 20-нд шинэчлэн батласан. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 5.3 Хуулийн төсөл боловсруулах, оролцогч талуудаар хэлэлцүүлэх; | Хуулийн төсөл боловсруулагдаж, УИХ-д өргөн баригдсан байна. | Хуулийн ажлын хэсэг | 2019 оны 11- 2020 оны 6-р сар | 5,000 | АХБ | Хуулийн батлагдсан үзэл баримтлалын хуулийн төсөл болон нэмэлт өөрчлөлт оруулах дагалдах хуулиудын холбогдох нэмэлтийг боловсруулсан. Азийн Хөгжлийн банкнаас гадаад, дотоод хуульч-зөвлөхүүдийг ажиллуулж байна. |
| | 5.4 Хуулийн төслийг УИХ-д өргөн барих; | | УУХҮЯ | 2019 оны 11- 2020 оны 6-р сар | Шаард-лагагүй | | 2021 оны Ажлын төлөвлөгөөнд шилжүүлсэн. |
| | 5.5 Хуулийг батлуулах нөлөөллийн ажил: лобби уулзалт хийх, хэвлэл мэдээллийн сурталчилгаа г м  зохион байгуулах; | | ОТОАХ | 1-5-р сар | | | Иргэний нийгмийн байгууллагуудаас 1 удаа хуулийн хэлэлцүүлгийг зохион байгуулсан. УУХҮЯ, ОҮИТБС-ын Ажлын албанаас цахимаар хуулийн төсөлд саналууд хүлээн авсан байна. |
| | 5.6 Хуулийн ач холбогдлыг хэвлэл, мэдээллээр танилцуулан сурталчлах; | | УУХҮЯ, Ажлын алба | 2019 оны 11- 2020 оны 12-р сар | 5,000 | АХБ | 2021 оны Ажлын төлөвлөгөөнд шилжүүлсэн. |
| | | | | **Тавдугаар зорилтын дүн** | **36,000** | **АХБ 16,000** | **ННФ 20,000** |

**Гуравдугаар зорилго: Ашиг хүртэгч жинхэнэ эздийн ил тод байдлыг хангахад чиглэсэн мэдээлэл, бүртгэлийн тогтолцоог сайжруулах, туршилтаар мэдээлэл цуглуулах;**
**Үндэслэл:** ОҮИТБС-ын Үндэсний зөвлөлөөс баталсан Замын зургийн дагуу 2020 онд төлөвлөсөн ажлуудыг хэрэгжүүлнэ. 2018 оны нэгтгэл тайлангаар 60 гаруй компани өөрсдийн эзэмшлийн мэдээллээ сайн дураар ил тод болгоод буй. Улсын бүртгэлийн тухай хуульд 2018 оны 11 сард нэмэлт өөрчлөлт орсны дагуу Монгол улсад бүртгэлтэй бүх хуулийн этгээдүүдийн хувь эзэмшигчдийн мэдээлэл олон нийтэд ил тод болсон. Гэсэн хэдий ч тус мэдээллийг цуглуулж буй төрийн байгууллагуудын чадавхийг бэхжүүлэх, ашиг хүртэгч эцсийн эзэн мөн эсэхийг баталгаажуулах, цахим системийг сайжруулах, олон нийтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, эрэн сурвалжлах сэтгүүл зүй, ИНБ-ын чадавхийг үргэлжлүүлэн бэхжүүлэх зэрэг Замын зурагт тусгасан үлдсэн ажлуудыг 2020 онд хэрэгжүүлэх шаардлага бий. Иймд эдгээр ажлуудыг энэ хэсэгт тусгасан болно.
**Зохицуулах байгууллага**: **Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам**

| ЗОРИЛТУУД | ТӨЛӨВЛӨСӨН АЖИЛ | ҮР ДҮН | ХАРИУЦАХ ТАЛ | ХУГАЦАА | ТӨСӨВ | | Гүйцэтгэл 2020 оны 12-р сарын 21-ны байдлаар |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Мөнгөн дүн (мян.төг) | Эх үүсвэр | |
| **Зорилт 6:** Монгол Улсын ОҮИТБС-ын 2013-2018 оны тайлангуудаар ил болсон ашиг хүртэгч эцсийн эздийн мэдээллийг ашиглах, түгээх; | 6.1 Монгол Улсын ОҮИТБС-ын 2013-2018 оны тайлангуудаар гарсан мэдээллийг багцлан хэвлүүлэх, түгээх; | Олон нийтэд АХЖЭ-ийн ил тод байдлын ач холбогдлын ойлголт нэмэгдэнэ. | УУХҮЯ, Ажлын алба | 9-10-р сар | 3,000 | Улсын төсөв | 2021 оны Ажлын төлөвлөгөөнд шилжүүлсэн. |
| | 6.2 Засгийн газрын байгууллагуудын Ажлын | АХЖЭ-ийн ил тод байдлын | УУХҮЯ, Ажлын алба | 3-12 сар | 1,000 | АХБ | 2021 оны Ажлын төлөвлөгөөнд шилжүүлсэн. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хэсгийг байгуулан, улирал бүр нэг удаа зөвлөлдөх; | үйл ажиллагаагаа уялдуулна. | | | | | |
| | 6.3 Монгол Улсын ашиг хүртэгч жинхэнэ эздийн цахим сайтыг монгол, англи хэл дээр бий болгох; | АХЭ-ийн ил тод байдлын мэдээллийн сан бий болно. | УУХҮЯ, Ажлын алба | 2019 оны 11- 2020 оны 12-р сар | Шаардла -гагүй | | Сайтыг болосруулах ажил хараахан дуусаагүй байна. |
| **Зорилт 7:** Ашиг хүртэгч жинхэнэ эздийн мэдээллийг цуглуулах системийг хөгжүүлэх, мэдээллийн үнэн бодит байдлыг баталгаажуулах институтыг бэхжүүлэх; | 7.1 УБЕГ, АМГТГ, ТЕГ-тай хамтран чадавх бэхжүүлэх сургалт зохион байгуулах; | Төрийн байгууллагын чадавх сайжирсан байна. | Ажлын алба | 12 -р сар | 1,000 | АХБ | 2021 оны Ажлын төлөвлөгөөнд шилжүүлсэн. |
| | 7.2 АХЖЭ-ийн мэдээллийг бүртгэдэг, хүлээн авдаг Улсын бүртгэлийн ерөнхий газартай хамтран тайлан гаргахад аргазүйн зөвөлгөө өгөх сургалтыг зохион байгуулах; | Мэдээлэл цуглуулах, солилцох механизм боловсронгуй болсон байна. | Зөвлөх компани | 12-р сар | 10,000 | АХБ | 2021 оны Ажлын төлөвлөгөөнд шилжүүлсэн. |
| | 7.3 ХАСХОМ-ээр тайлагнах улс төрд нөлөө бүхий этгээдийн мэдээллийн маягтыг АТГ-ийн сүлжээнд оруулах; | Улс төрд нөлөө бүхий этгээдийн мэдээлэл дэлгэрэнгүй болсон байна. | АТГ, Ажлын алба | 1-р сард | Шаардла -гагүй | | Холбогдох маягтын төслийг боловсруулан 3-р сард АТГ-д хүргүүлсэн бөгөөд УИХ-д танилцуулахаар бэлтгэж байна.. |
| | 7.4 Энэхүү зорилт үйл ажиллагааны явцын байдалд хагас жилд нэг удаа мониторинг үнэлгээ хийх, хэрэгжилтийг сайжруулах семинар зохион байгуулах; | Үйл ажиллагааны хэрэгжилтийн чанар сайжирсан байна. | ОТОАХ | 8-9 сард | 5000 | АХБ | Хэрэгжүүлээгүй. |
| **Зургаагаас Долоодугаар зорилтын дүн** | | | | | **20,000** | | **АХБ 17,000 Утсөв 3,000** |

**Дөрөвдүгээр зорилго: Монгол Улсын ОҮИТБС-ын 2019 оны тайлангийн нэгтгэлийн явцыг сайжруулах, тайланг хэлэлцэн батлах;**
**Үндэслэл:** Хараат бус хянагч, нэгтгэгчийн гэрээт ажлыг аль болох эрт эхлүүлэх,эхлэлтийн семинарыг үр дүнтэй зохион байгуулж, чанартай тайлан боловсруулах, тайлангийн ирцийг нэмэгдүүлэх, анхлан тайлагналын зөрүүг бууруулах, тайлангийн ашиглалтыг сайжруулах боломжтой болсон байна.
**Зохицуулах байгууллага**: **Ажлын алба**

| ЗОРИЛТУУД | ТӨЛӨВЛӨСӨН АЖИЛ | ҮР ДҮН | ХАРИУЦАХ ТАЛ | ХУГАЦАА | ТӨСӨВ | | Гүйцэтгэл 2020 12-р сарын 21-ний байдлаар |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Мөнгөн дүн (мян.төг) | Эх үүсвэр | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Зорилт 8**: Нэгтгэл тайланг боловсруулах, батлах; | 8.1 Нэгтгэл тайланг боловсруулах Хараат бус хянагч, нэгтгэгчийг сонгон шалгаруулах, Ажлын даалгаврыг батлах, зарлах, Үнэлгээний хороо байгуулах; | Хуулийн дагуу тендерийн бэлтгэл ажил хангагдсан байна. | Үнэлгээний хороо, Ажлын хэсэг | 1--р сар | 2,000 | Улсын төсөв | Грант Торнтон аудит ХХК-тай 2020,11,02-нд гэрээ байгуулсан. Тайлан боловсруулах ажлаа дуусган танилцуулж байна. |
| | 8.2 Эхлэлийн семинарыг зохион байгуулж, 2019 оны тайлангийн хамрах хүрээг батлах; | Тайлангийн хамрах хүрээ тодорхойлогдсон байна. | Хараат бус хянан нэгтгэгч, Ажлын хэсэг | 4-5-р сар | 2,000 | АХБ | Эхлэлийн семинарыг 2020 оны 11-р сарын 6-нд зохион байгуулж, тайлангийн хамрах хүрээг тодорхой болгосон: Монгол Улсын олборлох салбарын тэргүүлэх 171 компанийн ОҮИТБС-ын тайлангуудыг тулган баталгаажуулсан байна. Зардал 1,454.0 төгрөг |
| | 8.3 2019 оны тайланг цахимаар хүлээн ав ах, шаардлагатай заавар зөвлөмжийг өгөх, мессеж илгээх, гарын авлагыг сайжруулах, сурталчилах; | Тайлангийн ирц сайжирсан байна. | Ажлын алба, УУХҮЯ | 1-6-р сар | 500 | Улсын төв | Тусгай зөвшөөрөл эзэмшигч, газрын тосны гэрээт компаниудад тайлангаа гаргах мэдээллийг Мобиком, Юнител-ээр тус бүр 3 удаа масс-мессежээр явуулсан байна. 2 яам, 5 агентлаг, аймаг, дүүргүүд[2] ОҮИТБС-ын тайлангаа гаргасан байна. 0,395 төгрөг |
| | 8.4 2019 оны нэгтгэл хамрагдсан компаниудад 3 удаагийн сургалт зохион байгуулах, тайлангийн ач холбогдлыг таниулан ойлгуулах; | Нэгтгэлийн явцад үүсэх хүндрэлүүд багасч, мэдээллийн баталгаажуулалт сайжирна. | Хараат бус хянан нэгтгэгч, Ажлын алба | 6-7-р сар | 2,000 | АХБ | Тайлангийн шинэ маягтын аргазүйн зөвлөгөө өгөх 4 удаагийн цахим сургалт зохион байгуулагдсан байна. |
| | 8.5 Нэгтгэл тайланг боловсруулах, хэлэлцэх, батлах; | Нэгтгэл тайланг 11-р сард багтаж баталсан байна. | Хараат бус хянан нэгтгэгч, Ажлын хэсэг, Үндэсний зөвлөл | 8-11-р сар | 119,955,0 | Улсын төсөв | Хүлээгдэж байна. 90 хувь107,959.5 төгрөгийг төлсөн |
| | 8.6 УИХ-ын холбогдох хороодын нэгдсэн уулзалт хийж ОҮИТБС болон 2019 оны нэгтгэл батлагдсан тайлангаар хэлэлцүүлэг хийх | Тайлангийн чанар сайжирсан байна | ОТОАХ | 11-12-р сар | 2,000 | АХБ | 2021 оны Ажлын төлөвлөгөөнд шилжүүлсэн. |

[2] СЯ, БОАЖЯ,ТЕГ, АМГТГ, ГЕГ, НДЕГ, МХЕГ, Баянхангайгаас бусад бүх дүүргүүд, Баян-Өлгий, Төв аймгаас бусад бүх аймгууд ОҮИТБС-ын 2019 оныхоо тайлангаа гаргаад байна.

| | | |
|---|---|---|
| **Наймдугаар зорилтын дүн** | **195,930** | **АХБ 6,000 Улсын Төсөв 189,930** |

**Тавдугаар зорилго: Үндэсний болон орон нутгийн түвшинд ОҮИТБС-ыг хэрэгжүүлсний үр нөлөө, ач холбогдол мэдээлэл сургалт сурталчилгааны ажлыг идэвхжүүлэх;**
**Үндэслэл:** ОҮИТБС-ыг хэрэгжүүлсэн үр нөлөөний талаар оролцогч талуудын ойлголт мэдлэг сайжирснаар хийгдэж буй үйл ажиллагааны үр дүнг нэмэгдүүлэх чухал үүрэгтэй юм. Нутгийн удирдлага, нутгийн иргэд чадвах, мэдлэгтэй болсноор үүсэж болзошгүй сөрөг нөлөөллөөс сэргийлэхэд дэмжлэг болох учир үндэсний түвшинд болон орон нутгийн түвшинд үргэлжлүүлэн зохион байгуулахаар энд төлөвлөлөө.
**Зохицуулах байгууллага: Ажлын алба**

| ЗОРИЛТУУД | ТӨЛӨВЛӨСӨН АЖИЛ | ҮР ДҮН | ХАРИУЦАХ ТАЛ | ХУГАЦАА | ТӨСӨВ | | Гүйцэтгэл 2020 оны 12-р сарын 21-ны байдлаар |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | Мөнгөн дүн (мян.төг) | Эх үүсвэр | |
| **Зорилт 9.**Үндэсний түвшний мэдээлэл харилцааг идэвхжүүлэх; | 9.1 Мэргэжлийн холбоодтой (МУУҮА, Нүүрс Ассоциац, МҮХАҮТ, МБЗ) хамтын ажиллагааг өргөжүүлэх, сургалт семинар зохион байгуулах; | Мэргэжлийн холбоодын мэдлэг ойлголт нэмэгдсэн байна. | Мэргэжлийн холбоод, УУХҮЯ, Ажлын алба | 10-11-р сар | 1,000 | АХБ | 2021 оны Ажлын төлөвлөгөөнд шилжүүлсэн. |
| | 9.2 Төрийн бус байгууллага, бодлогын хүрээлэнгүүдтэй уулзалт зохион байгуулж, санал солилцох; | Тухайн байгууллагууд ын мэдлэг ойлголт нэмэгдсэн байна. | Иргэний нийгмийн байгууллагууд, Ажлын алба | Улирал тутамд | 3,000 | АХБ | 2021 оны Ажлын төлөвлөгөөнд шилжүүлсэн. |
| | 9.3 УИХ-ын Эдийн засаг, Төсвийн байнгын хороо, Засгийн газрын хуралдаанд Монгол Улс дахь ОҮИТБС-ын хэрэгжилтийн үр нөлөө, ач холбогдол, цаашдын зорилтыг танилцуулах; | Гишүүдийн мэдлэг, ойлголт нэмэгдсэн байна. | Үндэсний зөвлөл, УУУХЯ | 12-р сар | Шаардла -гагүй | | 2021 оны Ажлын төлөвлөгөөнд шилжүүлсэн. |
| **Зорилт 10**: Орон нутгийн түвшин дэх мэдээлэл харилцааны ажлуудыг үргэлжлүүлэх; | 10.1 Төвийн бүсийн III чуулган, сургалтыг Булган аймагт (6 аймаг, 100 хүн) зохион байгуулах; зөвхөн сургалт биш харилцан туршлага солилцох уулзалт хийх | Бүсийн түвшинд туршлага солилцож, дэд зөвлөлийн чадавх бэхэжсэн байна. | Холбогдох аймгуудын ЗДТГ, Ажлын алба | 11-р сар | 10,000 | АХБ | 2021 оны Ажлын төлөвлөгөөнд шилжүүлсэн. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 10.2 Аймгийн дэд зөвлөлүүд 2020 оны үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх, бүсийн семинарын үеэр хэрэгжилтийг тайлагнах замаар туршлага дэлгэрүүлэх, | Бүсийн түвшинд туршлага солилцож, дэд зөвлөлийн чадавх бэхэжсэн байна. | Холбогдох аймгуудын ЗДТГ, Ажлын алба | 11-р сар | 10,000 | АХБ | 19[3] аймгийн ОҮИТБС-ын дэд зөвлөл 2020 оны төлөвлөгөөгөө батлуулан ирүүлсэн. Ажлын албаны вебсайт дээр байршуулсан. |
| | 10.3 Баруун бүсийн II чуулган, сургалттыг Завхан аймагт /5 аймаг, 100 хүн/ зохион байгуулах; | Бүсийн түвшинд туршлага солилцож, дэд зөвлөлийн чадавх бэхэжсэн байна. | Холбогдох аймгуудын ЗДТГ, Ажлын алба | 11-р сар | 20,000 | АХБ | 2021 оны Ажлын төлөвлөгөөнд шилжүүлсэн. |
| | 10.4 ОҮИТБС-ын аймаг, сумын дэд зөвлөлийн сайн туршлагыг судалгаа хийх, холбогдох аргачлалыг боловсруулах, дэлгэрүүлэх; | Бүсийн түвшинд туршлага солилцож, дэд зөвлөлийн чадавх бэхэжсэн байна. | Холбогдох аймгуудын ЗДТГ, Ажлын алба | 11-р сар | Шаардла-гагүй | | 2021 оны Ажлын төлөвлөгөөнд шилжүүлсэн. |
| | 10.5 Аймаг бүр ОҮИТБ-ын тайлангаар Нийтийн сонсголын хуулийн дагуу ерөнхий болон төсвийн хяналтын сонсгол явуулах замаар олон нийтийн мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, улмаар тэдний саналд үндэслэн аймгийн дэд зөвлөлүүд 2021 оны төлөвлөгөө гаргах; | Бүсийн түвшинд туршлага солилцож, дэд зөвлөлийн чадавх бэхэжсэн байна. | Холбогдох аймгуудын ЗДТГ, Ажлын алба | 12-р сар | 10,000 | АХБ | 2021 оны Ажлын төлөвлөгөөнд шилжүүлсэн. |
| | 10.6 Дэд зөвлөлийн туршлага солилцох аялалыг жишиг сумдын аль нэг дээр зохион байгуулах, үзүүлэх сургалт зохион байгуулах; | Бүсийн түвшинд туршлага солилцож, дэд зөвлөлийн чадавх бэхэжсэн байна. | ТАН эвсэл | 8-р сар | 10,000 | АХБ | 2021 оны Ажлын төлөвлөгөөнд шилжүүлсэн. |

[3] Ар, БӨ, Бу, Дар, Дуговь, Договь, Хөв, Ор, Сэл, ӨГ, Өв, До, За, СБ, Тө, Ув, ГА, Хэ, Нийслэл

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Зорилт 11:** ОҮ-ийн мэдээлэл, харилцаа, сурталчилгааны стратегийг шинэчлэх; | 11.1 ОҮ- ийн мэдээлэл, харилцаа, сурталчилгааны суурь судалгааг хийх, стратеги, ажлын төлөвлөгөө боловсруулан, батлуулах; | Мэдээлэл, харилцаа, сурталчилгааны үндсэн баримт бичигтэй болсон байна. | УУХҮЯ | 12- р сар | Шаардла -гагүй | | Холбогдох ажлаа Ажлын хэсэгт танилцуулсан, шинэчилж байна.. |
| | 11.2 Сургалт, сурталчилгаа, үзэсгэлэн, бага хурал, уулзалтуудад зориулан хэвлэмэл бүтээгдэхүүн бэлтгэх, хэвлүүлэх; | Олон нийт мэдлэг, мэдээлэлтэй болсон байна. | УУХҮЯ, Ажлын алба | 2-12-р сар | 10,000 | Улсын төсөв | 2021 оны Ажлын төлөвлөгөөнд шилжүүлсэн. |
| | 11.3 Өдөр тутмын сонин, телевиз зэрэг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилгааны ажлуудыг зохион байгуулах; | Олон нийтийн мэдлэг, ойлголт нэмэгдсэн байна. | УУХҮЯ, Ажлын алба | 1-12-р сар | 5,000 | Улсын Төсөв | Ажлын албаны фейсбуук-ийг ажиллуулж, мэдээ байршуулж, мэдээлэл түгээж байна. |
| **Зорилт 12.** 2021 оны баталгаажуулалтад бэлтгэх; | 12.1 ОҮИТБС-ын 2019 оны стандартын шаардлага бүрээр өөрийн үнэлгээ хийх, дүнг хэлэлцэх, авах арга хэмжээний төлөвлөгөө гаргах; | Баталгаажуулалтын бэлтгэл ажил хангасан байна. | ОТОАХ | 9-12-р сар | 1,000 | АХБ | 2021 оны Ажлын төлөвлөгөөнд шилжүүлсэн. |
| **Есөөс Арван хоёрдугаар зорилтын дүн** | | | | | **101,000** | **АХБ 86[4],000 УТөсөв 15,000** | |
| **БҮГД ДҮН: мян.төг** | | | | | **423,930** | **АХБ 136,000 УТөсөв 212,430 ННФ 20,000 ЕСБХБ 10,000** | |

**2018 оны ОҮИТБС-ын Нэгтгэл тайлангаар БДО компаниас гаргасан зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх хүрээнд Ажлын төлөвлөгөөнд шинээр тусгасан үйл ажиллагаанууд**

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| **Зорилт 13**: 2018 оны нэгтгэл тайлангаар өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх; | 13.1 Олон талт оролцогчдын бүлгийн бүрэлдэхүүнд жендерийн тэнцвэрийг хангахын тулд оролцогч тал бүрийн төлөөлөлтэй хэлэлцүүлэг хийж, арга хэмжээ авах; | Жендерийн тэнцвэртэй байдлыг хангахад талууд нэгдмэл ойлголттой болсон байна. | УУХҮЯ | 11- р сар | Шаардла -гагүй | | 2021 оны Ажлын төлөвлөгөөнд шилжүүлсэн. |
| | 13.2 Дэд зөвлөлийн дүрмийг хэрэгжүүлэх боломжийг олгохын тулд илүү практикт тулгуурлан сайжруулах, | Орон нутагт мэдээллийн хүртээмжийг нэмэгдүүлнэ. | ОТОАХ | | 10,1;10,2 –д заасан | | ЭБСИТБ-ын хуулийн төсөлд холбогдох заалтыг оруулсан. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Олон талт оролцогчдын бүлэг нь дэд зөвлөлийн санхүүжилттэй холбоотой Засгийн газрын тогтоолыг хэрэгжүүлэх талаар арга хэмжээ авах; | | | | ажил гэж үзнэ. | | |
| | 13.3 Төрийн болон орон нутгийн өмчит компаниудын ТУЗ-ын гишүүдийн нэр, ажил албан тушаал, ажлын хаяг зэрэг мэдээллийг Эрдэнэс Монгол ХХК болон бусад компани гэсэн ангиллаар гаргаж, тайланд тусгах, мөн төрийн болон орон нутгийн өмчит компаниудын ТУЗ-ын гишүүдийн цалин, урамшуулал, үзүүлсэн хөнгөлөлт, томилолтын зардлыг охин компани бүрээр гаргаж, тайланд тусгах; | Мэдээллийн хүртээмж нэмэгдсэн байна. | Холбогдох төрийн өмчит ААН-үүд | 6-р сар | 1,1- д заасан ажил гэж үзнэ. | Шаард ла-гагүй | ТӨК-үүдийн шинэ мэдээллийг шинэчилсэн маягтуудад оруулж, Үндэсний статисткийн хороо шинэ маягтуудыг 2020 оны 2-р сарын 21 нд зөвшөөрсөний дагуу Ууу уурхай, хүнд үйлдвэрийн 3- р сарын 5-ны А/37 дугаар тушаалаар батлаж, Хууль зүй, дотоодын хэргийн яаман дээр 4-р сарын 21-нд бүртгэгдэж, www.legalinfo.mn дээр хэвлэгдэн, мөрдөгдөж эхлэсэн байна.<br>Маягтын дагуу цахим сургалт зохион 1,2 ажлын цахим сургалт зохион байгуулсан. |
| | 13.4 ОҮИТБС-ын стандартын 2.5-д заасны дагуу ОҮИТБС-ын хэрэгжүүлэгч орнууд хайгуул, олборлолт, газрын тос, байгалийн хийн олборлолт эрхлэх тусгай, гэрээнд оролцох эрх бүхий өргөдөл гаргасан аж ахуйн нэгж, байгууллагуудын бенефицарь эздийн бүртгэлийг олон нийтэд нээлттэй байлгах; | Мэдээллийн хүртээмж нэмэгдсэн байна. | Ажлын алба | | 5,4- т заасан ажил гэж үзнэ. | ЭБСИ ТБт хуу-лийн хү-рээнд шийд-вэрлэх | ЭБСИТБ-ын хуулийн төсөлд холбогдох заалтыг оруулсан. |
| | 13.5 Олборлох салбартай холбоотой мэдээллийг эхлээд УУХҮЯ- д төвлөрүүлэх, мэдээллийг хянаж, шалгасны дараа бусад Засгийн газрын байгууллагад өгөх; | Мэдээллийн зөрүүтэй байдал буурна. | Ажлын алба | 12-р сар | | ЗГ-ын тог-тоол гаргах замаар шийд-вэр-лэх | 2021 оны Ажлын төлөвлөгөөнд шилжүүлсэн. |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | 13.6 Орон нутгийн холбогдох төрийн байгууллагуудын хүлээн авсан хандивын мэдээллийг иж бүрэн, үнэн зөв цахим сайтад тайлагнах; | Мэдээллийн хүртээмж нэмэгдсэн байна. | Холбогдох аймгуудын ЗДТГ | 9-р сар | Шаардлагагүй | | 2021 оны Ажлын төлөвлөгөөнд шилжүүлсэн. |
| | 13.7 Тайланд хамрагдаж байгаа орлогын урсгалуудыг төсөл(тусгай зөвшөөрөл) тус бүрээр ялган, тайлагнах, ажилчдын мэдээллийг дэлгэрэнгүй болгох (ажилчдын насны талаарх мэдээлэл нэмэлтээр оруулах), баяжуулах, боловсруулах үйлдвэрлэлийн дэлгэрэнгүй мэдээллийг тайлангийн маягтад тусгаж, оруулах, тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй гэрээний үндсэн дээр хамтран ажиллах гэрээ байгуулсан оператор, туслан гүйцэтгэгч болон ханган нийлүүлэгч компаниудын дэлгэрэнгүй мэдээллийг оруулах; | Мэдээллийн хүрээмж нэмэгдсэн байна. | Ажлын алба, холбогдох компаниуд | | 1,1- д заасан ажил гэж үзнэ. | | Эдгээр мэдээллүүдийг шинэчилсэн маягтуудад оруулж Үндэсний статисткийн хороо шинэ маягтуудыг 2020 оны 2-р сарын 21 нд зөвшөөрсөний дагуу Ууу уурхай, хүнд үйлдвэрийн 3- р сарын 5-ны А/37 дугаар тушаалаар батлаж, Хууль зүй, дотоодын хэргийн яаман дээр 4-р сарын 21-нд бүртгэгдэж, www.legalinfo.mn дээр хэвлэгдэн, мөрдөгдөж эхлэсэн байна. |
| | 13.8 Засгийн газрын болон компаниудаас үндсэн болон нэмэлт мэдээллийн маягтыг цахим системд оруулах; | Мэдээллийн хүрээмж нэмэгдсэн байна. | Ажлын алба, холбогдох компаниуд | | Шаард-лагагүй | | 2020 оны 5-р сарын 24-ний дотор оруулсан хэдий ч ажиллахгүй байсныг Интерактив ХХК-тай хамтарч ажилласны үр дүнд 8-р сарын 17-ноос идэвхжүүлсэн. 633 Компани шинэ маягтаар тайлангаа давхар гаргасан. |
| | 13.9 Илтод.гэрээ.мн сайтад гэрээний бүх нөхцлийг иж бүрэн, ямар нэгэн зүйл заалт хасахгүй байх; | Мэдээллийн хүрээмж нэмэгдсэн байна. | Ажлын алба, | | | | Аймаг, нийслэл, дүүргүүд гэрээнүүдээ оруулж байна. 12-р сарын 10-ны байдлаар 796 гэрээ оруулаад байна[5]. |
| **Зорилт 14**: Үндэсний зөвлөлөөс гаргасан санал, зөвлөмжүүдийн хүрээнд хэрэгжүүлэх үйл | 14.1 Үйл ажиллагааны үр дүнг дүгнэх аргачлалыг боловсруулж, санал авч, | Үр дүнг бодитой дүгнэх | ОТОАХ, Ажлын алба | 1-2-р сар | Шаард-лагагүй | | Аргачлалын төслийг боловсруулсан. Санал авахаар хүлээгдэж байна. |

[5] Архангай- 2, Баян-Өлгий -7, Баянхонгор-16, Булган-77, Говь-Алтай-22, Дорноговь- 62, Дорнод-34, Дундговь-74, Завхан-15, Өвөрхангай-48, Өмнөговь-34, Сүхбаатар-34, Сэлэнгэ-56, Төв-122, Увс-13, Ховд-14, Хөвсгөл-2, Хэнтий-65, Дархан-Уул 27, Улаанбаатар-56(Баянгол 19, Баянзүрх 1, Сонгинохайрхан 2, Хан-Уул 6, Чингэлтэй 2, Налайх 15, Багахангай 5, Сүхбаатар-6), Орхон-8, Говьсүмбэр-3 гэрээ

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| ажиллагааг хангах арга хэмжээ авах; | Ажлын хэсэгт танилцуулан, батлуулах; | боломжтой болсон байна. | | | | | |
| | 14.2 Орон нутгийн байгууллагуудтай хамтран ажиллах журмыг боловсруулж, УУХҮС-ын тушаал боловсруулж, санал авч, Ажлын хэсэгт танилцуулах; | Орон нутагт хэрэгжүүлэх үйл ажиллагаа сайжирсан байна. | ОТОАХ, Ажлын алба | 1-3-р сар | Шаард-лагагүй | | Журмын төслийг боловсруулсан. Санал авахаар хүлээгдэж байна. |
| | 14.3 Баяжуулах үйлдвэрийн тайлагналын маягтыг боловсруулах Ажлын хэсгийг байгуулах, бүх талууд хамтран ажиллах; | Баяжуулах үйлдвэрүүдийн ил тод байдлыг нэмэгдүүлнэ. | ОТОАХ, Ажлын алба | 1-2-р сар | Шаард-лагагүй | . | Үндэсний статисткийн хороо шинэ маягтуудыг 2020 оны 2-р сарын 21 нд зөвшөөрсөний дагуу Ууу уурхай, хүнд үйлдвэрийн 3- р сарын 5-ны А/37 дугаар тушаалаар батлаж, Хууль зүй, дотоодын хэргийн яаман дээр 4-р сарын 21-нд бүртгэгдэж, www.legalinfo.mn дээр хэвлэгдэн, мөрдөгдөж эхлэсэн байна. |

**ОҮИТБС-ын Ажлын алба**

**Тайлбар:** **Хэрэгжсэн, эсхүл хэрэгжих шатандаа байгаа. 29 ажил**

**Хүлээгдэж байгаа, 2021 онруу хойшилсон- 24 ажил**

**Хэрэгжээгүй 2 ажил**